



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/94/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Булганчимэг Утас: 51-261628 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛТ
ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ТЭРГҮҮЛЭХ
ЗӨВЛӨХ Ц.ХАЛИУН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.20 № 07/242
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол Шинжлэх Ухааны Яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар томилогдсон комисс төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан 52 нэр төрлийн 135,932.7 мянган төгрөгийн анхны өртөг, 19,717.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгө болох автотээврийн хэрэгсэл, компьютер дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшлыг БШУЯ-нд жагсаалтаар хүлээлгэн өгсөн байна.

Төслийн үйл ажиллагаа дуусч харилцах дансны хүүгийн орлогын үлдэгдэл 39,517.9 мянган төгрөгийг Сангийн яаманд шилжүүлэн, Төрийн банкин дахь тусгай данс 2023 оны 7 дугаар сарын 27-ны өдөр, Төрийн сан банкин дахь дэд данс 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдрүүдэд сүүлийн төлбөр хийж хаагдсанаар 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Зээлийн гэрээний дагуу төслийн нийт хугацаа буюу 2015-2023 онд үйл ажиллагааны баталсан төлөвлөгөөний дагуу нийт 5 бүрэлдэхүүн хэсгийн 152 ажлыг 100.0 хувь хэрэгжүүлж, 73,386,159.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Z:\Yawsan_Bichigi\2024\0220 SNAG-6.Docx

0001050446

Аудитын хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжээс төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн эцсийн тайланг боловсруулан Одамис системд байршуулсан байна. Дэлхийн банк төслийн үр дүн, хаалтын тайланг боловсруулан хэрэгжүүлэгч яамнаас санал авч, Дэлхийн банкны Захирлуудын зөвлөлийн хурлаар баталгаажуулаагүй байгаа тул олон нийтэд мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,562,553,460.77	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,560,153,460.77	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,560,153,460.77	-
3121	Төгрөг	46,445,139.89	-
31210	Төрийн сангийн харилцах	46,445,139.89	-
3122	Гадаад валют	3,513,708,320.88	-
31221	Төрийн сангийн харилцах	3,513,708,320.88	-
34	УРЬДЧИЛГАА	2,400,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	2,400,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,394,030.13	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,394,030.13	-
392	Биет хөрөнгө	24,394,030.13	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	80,200,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(58,144,999.71)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,400,739.00	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,110,863.52)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,532,000.00	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,482,845.64)	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	7,800,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,800,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,586,947,490.90	-
4	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,586,947,490.90	-
51	Засгийн газрын хувь оролцоо		
512	Хуримтлагдсан үр дүн	3,586,947,490.90	-
51210	Өмнөх үеийн үр дүн	6,704,743,786.08	3,586,947,490.90
51220	Тайлант үеийн үр дүн	(3,117,796,295.18)	(3,586,947,490.90)
5	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,586,947,490.90	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,608,680,000.00	898,479,963.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,608,680,000.00	898,479,963.44
120	Нийтлэг татварын бус орлого	7,608,680,000.00	898,479,963.44
120002	Бусад орлого	385,000.00	-
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	7,608,295,000.00	898,479,963.44
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,237,864,487.14	4,455,222,431.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,351,129,587.14	4,455,222,431.06
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	10,351,129,587.14	4,455,222,431.06
210101	Үндсэн цалин	163,920,000.00	87,895,714.43
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	20,490,000.00	10,974,464.38
210304	Байрны түрээсийн зардал	28,615,70.00	16,840,134.00
210401	Бичиг хэргийн зардал	1,556,570.93	1,694,889.23
210402	Тээвэр, шатахууны зардал	1,670,657.24	1,200,000.00
210403	Шуудан холбооны зардал	1,968,563.90	1,008,043.87
210404	Ном хэвлэлийн зардал	942,800.00	621,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	135,455.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	814,000.00	300,000.00
210702	Дотоод албан томилолт	4,730,500.00	6,925,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	10,111,695,386.07	4,317,840,400.98
210808	Банкны үйлчилгээний хураамж	184,339.50	165,653.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,194,555.00	4,945,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	11,046,513.50	4,676,475.48
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	886,734,900.00	-
223001	Бусад хөрөнгө	886,734,900.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(3,629,184,487.14)	(3,556,742,467.62)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	511,388,191.96	29,030,425.45
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	511,388,191.96	29,030,425.45
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	59.235.448673
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	19,717,554.65
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		39,517,894.08
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(3,117,796,295.18)	(3,586,947,490.90)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,608,680,000.00	898,479,963.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,608,680,000.00	898,479,963.44
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,608,680,000.00	898,479,963.44
120002	Бусад орлого	385,000.00	-
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	7,608,295,000.00	898,479,963.44
2	УРСГАЛ ЗАРДАЛ	5,945,584,649.40	4,448,145,955.58
21	Бараа, ажил үйлчилгээний зардал	5,945,584,649.40	4,448,145,955.58
210101	Үндсэн цалин	163,920,000.00	87,895,714.43
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	20,490,000.00	10,974,464.38
210304	Байрны түрээсийн зардал	28,615,701.00	14,440,134.00
210401	Бичиг хэргийн зардал	1,556,570.93	1,694,889.23
210402	Тээвэр, шатахууны зардал	1,200,000.00	1,200,000.00
210403	Шуудан холбооны зардал	1,968,563.90	1,008,043.87
210404	Ном хэвлэлийн зардал	942,800.00	621,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	135,455.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	814,000.00	300,000.00
210702	Дотоод албан томилолт	4,730,500.00	6,925,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	5,717,667,619.07	4,317,840,400.98
210808	Банкны үйлчилгээний хураамж	184,339.50	165,653.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,194,555.00	4,945,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,663,095,350.60	(3,549,665,992.14)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	886,734,900.00	39,517,894.08
223001	Бусад хөрөнгө худалдан авсан	886,734,900.00	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	39,517,894.08
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(886,734,900.00)	(39,517,894.08)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	Санхүүгийн мөнгөн орлогын дүн	511,388,191.96	29,030,425.45
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	511,388,191.96	29,030,425.45
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	511,388,191.96	29,030,425.45
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,287,748,642.56	3,560,153,460.77
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,272,404,818.21	3,560,153,460.77
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,560,153,460.77	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,704,743,786.08	6,704,743,786.08
Тайлант үеийн үр дүн	-	(3,117,796,295.18)	(3,117,796,295.18)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	3,586,947,490.90	3,586,947,490.90
Тайлант үеийн үр дүн	-	(3,586,947,490.90)	(3,586,947,490.90)
2023 оны 9-р сарын 30-наарх үлдэгдэл	-	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,866,857,200.00	4,448,040,198.38	418,817,001.62	91.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,866,857,200.00	4,448,040,198.38	418,817,001.62	91.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,866,857,200.00	4,448,040,198.38	418,817,001.62	91.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,800,000.00	14,440,134.00	14,359,866.00	50.2
210303	Байрны түрээс	28,800,000.00	14,440,134.00	14,359,866.00	50.2
2104	Хангамж, бараа материалын зардал	7,630,900.00	4,659,388.10	2,971,511.90	61.0
210401	Бичиг хэрэг	1,630,900.00	1,694,889.23	(63,989.23)	103.9
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	1,200,000.00	1,200,000.00	50.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,008,043.87	991,956.13	50.5
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	621,000.00	379,000.00	62.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	135,455.00	464,545.00	22.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	300,000.00	700,000.00	30.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	300,000.00	700,000.00	30.0
2107	Томилолт, зочны зардал	6,925,200.00	6,925,200.00	-	-
210702	Дотоод албан томилолт	6,925,200.00	6,925,200.00	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,816,581,600.00	4,416,770,476.28	399,811,123.72	91.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,816,581,600.00	4,416,770,476.28	399,811,123.72	91.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,919,500.00	4,945,000.00	974,500.00	83.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,919,500.00	4,945,000.00	974,500.00	83.5
222	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-	-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,866,857,200.00	898,479,963.44	3,968,377,236.56	18.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,866,857,200.00	898,479,963.44	3,968,377,236.56	18.5
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,866,857,200.00	898,479,963.44	3,968,377,236.56	18.5
	Тохируулах бичилт		(10,593,225.83)		
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,560,153,460.77		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4	4	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 73,410,653.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
								Тоо	Дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хавсралт: Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн тайланг бүрэлдэхүүн тус бүрээр 73,386,159.0 мянган төгрөгийн төлөвлөгөө гүйцэтгэлийг зэрэгцүүлээгүй, нийт дүнгээр ам.доллараар илэрхийлэн тайлагнасан, Сангийн яамтай нийт зээлийн ашиглалтын эцсийн тооцоог баталгаажуулан хавсаргаагүй	1	73,386,159.0	1	73,386,159.0			1	73,386,159.0
2	Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 4,676.5 мянга, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 19,717.5 мянган төгрөгийг нийлүүлэн нийт 24,394.0 мянган төгрөгийг элэгдлийн зардлаар тайлагнасан	1	24,394.0			1	24,394.0	1	24,394.0
Дүн		2	73,410,553.0	1	73,386,159.0	1	24,394.0	2	73,410,553.0

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			